



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 11484

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар (Д.Батцэцэг)-т шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 300,000,000.0 (гурван зуун сая) төгрөгийг "Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт"-д батлагдсан "Эрүүл мэндийн байгууллагын агаар сэлгэлтийн системийг сайжруулах ажил (Улаанбаатар хот)" -ийн хөрөнгөөс гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг зохих журмын дагуу бүртгэлжүүлж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханганд ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/20 дугаар захирамжийн хавсралтаар баталсан жагсаалтын "15" дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1725022319

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
04 дүүрэг сарын 11.-ны өдрийн
11489 дүүрэг захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2025 ОНЫ
ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ ИХ ЗАСВАРЫН
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжи х дүн
		Эхлэх	Дуусах		
1	Эрүүл мэндийн байгууллагын агаар сэлгэлтийн системийг сайжруулах ажлын зураг, төсөв (Улаанбаатар хот)	2025	2025	300.0	300.0
Нийт дүн				300.0	300.0

ବୁଦ୍ଧିମତ୍ତି ରୀ ପ୍ରକାଶନିକାରୀ ।

የመስቀልና አዎች ከተማውን የሚከተሉት ቀን ስምምነት ተረጋግጧል፡፡ ይህንን ቀን ከፌዴራል ተስፋይ የሚከተሉት ቀን ስምምነት ተረጋግጧል፡፡ ይህንን ቀን ከፌዴራል ተስፋይ የሚከተሉት ቀን ስምምነት ተረጋግጧል፡፡

የፌዴራል ተሸጠው የፌዴራል ንግድ ስርዓት ተስተካክለ ይችላል

ଶ୍ରୀ ହରପାତା ପଟ୍ଟାଳ


Now $\frac{1}{\theta}$ is $\frac{1}{\theta}$ in the denominator

କହାନୀ

ପ୍ରକାଶନ ମିଟ୍ର



የኢትዮጵያ
የኢትዮጵያ ማኅበር አስተዳደር የፌዴራል



၁၃။ အာရုံချိန် ၆၆ အာရုံချိန် ၁၀၅။

(၁၁။ မြန်မာ) - ငါ အသုချင် အသုချင် အပိုမိုကြပ်တော်။